



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/97

Улаанбаатар хот

Аргачлал шинэчлэн
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын 2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрчим хүчний салбарын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тушаал шийдвэр болон бусад баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан аргачлалыг хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаанд мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллахыг яамны холбогдох газар, хэлтэс, салбарын үйлдвэр, компаниудын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж, салбарын үйлдвэр, компаниудад хүргүүлэх, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Х.Бекболат/-т даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Аргачлал батлах тухай” Эрчим хүчний сайдын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 227 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Н.ТАВИНБЭХ

170600238

**ЭРЧИМ ХҮЧНИЙ САЛБАРЫН
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ,
ТУШААЛ, ШИЙДВЭР БОЛОН БУСАД БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх үйл ажиллагаанд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” /цаашид “нийтлэг журам” гэх/-ыг удирдлага болгоно.

1.2. Эрчим хүчний салбарт хэрэгжиж буй бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, улсын төсөв болон гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, гэрээ хэлэлцээрийн хэрэгжилт, тэдгээрээр хүлээсэн үүргийн биелэлт, удирдлагын тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, үр дүнгийн үзүүлэлтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнд нь үнэлгээ өгөхөд энэхүү аргачлалыг баримтална.

1.3. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь салбарын бодлого, төлөвлөлт, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх, удирдлагыг мэдээлэл, зөвлөмжөөр хангаж тухайн байгууллага, нэгжийн үйл ажиллагааг сайжруулахад оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

2.1. Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг дараах аргачлалын дагуу хувиар илэрхийлэн үнэлнэ:

$$\text{ХЭРЭГЖИЛТ} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} \times 100\%$$

2.1.1. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хүрсэн түвшинг тоо болон чанараар илэрхийлэх боломжгүй үед хэрэгжилтийн хувийг тодорхойлоход дараах аргачлалаар тооцно:

а/ зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь;

б/ тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70.0 хувь;

в/ тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь;

г/ тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол 30 хувь;

д/ тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон үйл ажиллагааг авч эхэлж байгаа эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийг "0" хувь.

2.1.2. Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг 2.1, 2.1.1-т заасан аргачлалын дагуу тооцож, зорилт, арга хэмжээний дундаж үнэлгээгээр бодлогын зорилго, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцно:

а/ "үр дүнтэй" - зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь;

б/ "тодорхой үр дүнд хүрсэн" - зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70-99 хүртэл хувь;

в/ "эрчимжүүлэх шаардлагатай" - зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай бол 31-69 хүртэл хувь;

г/ "үр дүнгүй" - зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0-30 хүртэл хувь.

2.2. Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийн үнэлгээг дараах аргачлалаар тооцно:

2.2.1. "бүрэн хэрэгжсэн" - холбогдох шийдвэр гарч тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);

2.2.2. "хэрэгжих шатанд" - тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, санхүүгийн асуудлыг шийдсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд

шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байгаа бол 70 хувь (50-89 хүртэл хувь);

2.2.3. “хэрэгжилт хангалтгүй” - тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил болон боловсруулалт хийгдэж дууссан боловч зохион байгуулалт, төсөв, санхүүгийн асуудал шийдэгдээгүй бол 30 хувь (10-49 хүртэл хувь);

2.2.4. “хэрэгжээгүй”-тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа, бэлтгэл ажил хийгдэж боловсруулалтын шатанд байгаа болон тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 хувь (0-9 хүртэл хувь);

2.2.5. “хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”.

2.3. Үйл ажиллагааны төлөвлөгөө, гэрээ, тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилтийн үнэлгээг дараах аргачлалаар тооцно:

2.3.1. холбогдох шийдвэр гарч тавьсан зорилт, шалгуур үзүүлэлтдээ бүрэн хүрсэн, үр дүн гарсан бол 100 хувь;

2.3.2. арга хэмжээний хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаагүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь;

2.3.3. тухайн асуудлаар өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны удирдлага, байгууллагад өргөн барьсан, гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол 70.0 хувь;

2.3.4. зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол 50.0 хувь;

2.3.5. арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл ажил дуусаад, боловсруулалтын шатанд байгаа бол 30.0 хувь;

2.3.6. зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа, эсвэл хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол 0 гэж үзнэ.

2.4. Бодлогын баримт бичгийн зорилго, зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, үйл ажиллагааны төлөвлөгөө, тушаал, үүрэг даалгаврын хэрэгжилтийн ерөнхий дүнг гаргахдаа зорилт, арга хэмжээ, зүйл, заалт, төлөвлөсөн арга хэмжээ бүрийн хэрэгжилтийн арифметик дунджаар тооцно.

2.5. Сайдаас аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлт, стратеги төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхдээ бодлогын баримт бичиг үнэлэх аргачлалыг баримтална.

2.6. Хэрэгжилтийг тайлагнахдаа тухайн зорилт, арга хэмжээ, заалтын гүйцэтгэл, үр дүнг хоёр мянган тэмдэгтэд багтаана.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

3.1. Хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах байдлаар цогц хийнэ:

3.2.1. Үйл ажиллагааны төлөвлөгөө, тушаал, шийдвэр, үүрэг даалгаврын хэрэгжилт, тайлан, үр дүнгийн талаарх мэдээллийг хэрэгжүүлэгч, оролцогч байгууллагаас гаргуулах, материалыг судалж, зорилтын хэрэгжилт, үр дүнтэй уялдсан судалгаа явуулах, шаардлагатай бол тодотгол мэдээ авах;

3.2.2. Үйл ажиллагааны хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар яамны бүтцийн нэгжүүд, салбарын үйлдвэр, компаниуд, холбогдох бусад газар, хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, эрдэм шинжилгээний болон бусад байгууллагаас гаргасан тайлан, мэдээ мэдээллийг цуглуулан авч задлан шинжлэх замаар хяналт-шинжилгээнд ашиглах;

3.2.3. Цуглуулж авсан тайлан, шийдвэр, мэдээ мэдээлэл нь тухайн бодлогын зорилго, зорилтын хэрэгжилт, үр дүнг тодорхойлох, хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаатай хэрхэн нийцэж байгаад хяналт хийж, шаардлагатай бол газар дээр нь танилцаж нэмэлт мэдээлэл авах;

3.3. Хяналт-шинжилгээ хийж байх үеийн үзүүлэлтийн хэмжээ, түвшинг тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхээс өмнөх үеийн суурь өгөгдлүүдтэй буюу эсвэл урьдчилан тооцоолсноор хүрсэн байх ёстой үзүүлэлттэй харьцуулан үнэлгээ, дүгнэлт хийнэ.

3.4. Цуглуулсан мэдээ, мэдээллүүдээ нэгтгэн дүгнэх, харьцуулан судлах, задлан шинжлэх, чанарын түвшинг тогтоох, өгөгдөхүүнийг хэмжээсжүүлэх, ажлын ололт амжилт, хүрсэн үр дүнг хамт олны оролцоотой үнэлэх зэрэг хяналт-шинжилгээний аль тохиромжтой арга барилыг ашиглан хяналт-шинжилгээг хийнэ.

3.5. Хяналт-шинжилгээгээр илэрсэн алдаа дутагдлыг арилгах, цаашид хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний санал, зөвлөмж, холбогдох шийдвэрийн төслийг боловсруулж, удирдлагад танилцуулан холбогдох газарт хүргүүлнэ.

3.6. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг баримтжуулж нэгдсэн тайлан буюу танилцуулга бэлтгэнэ. Энэхүү тайлан, танилцуулгад дараах мэдээллийг тусгана:

3.6.1. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, зорилт, эрх зүйн үндэслэл, удирдамж, холбогдох баримт бичиг, багийн бүрэлдэхүүн, түүний гүйцэтгэсэн үйл ажиллагаа, хугацааны талаарх мэдээлэл,

3.6.2. Тухайн бодлогын зорилт, арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд хийгдэх үндсэн үйл ажиллагаа, төлөвлөсөн цаг хугацаа, хүний болон санхүүгийн нөөц, хүрэх үр дүнгийн талаарх мэдээлэл, гүйцэтгэсэн бодит ажил, санхүүжилт, нөөцийн ашиглалтын талаарх хүрсэн үр дүнг тоон болон чанарын түвшний тодорхой үзүүлэлтээр гаргаж, тайлбарлан тайлагнах,

3.6.3. Хяналт-шинжилгээний дүнд тодорхойлсон тоон болон чанарын үзүүлэлтийн түвшинг хүрэхийг зорьсон түвшин, үр дүнтэй харьцуулан бодлогын зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх явцад гарсан ололт амжилт, илэрсэн алдаа, дутагдлыг нэг бүрчлэн тогтоож, үнэлэлт дүгнэлт хийсэн талаарх мэдээлэл,

3.6.4. Хяналт-шинжилгээний явцад илэрсэн алдаа, дутагдлыг засах, хэрэгжилтийг зөв хангах талаар санал, зөвлөмж, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулах,

3.6.5. Хяналт-шинжилгээ хийхэд ашигласан судалгаа, харьцуулсан үзүүлэлтийн материалыг тайлан буюу танилцуулгад хавсаргана.

3.7. Хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамрагдсан талууд нь гүйцэтгэсэн ажлын тайлан, холбогдох судалгааны болон шаардлагатай бусад мэдээ, материалыг хяналт-шинжилгээ, үнэлгээний баг, эсвэл ажилтанд товлосон хугацаанд нь бүрдүүлж өгөх үүрэг хүлээнэ.

3.8. Хяналт-шинжилгээний дүгнэлт, санал, зөвлөмж нь бодлогын төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах, илэрсэн алдаа, дутагдал болон зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, түүнийг засах, оновчтой шийдвэр гаргах үндэслэл болно.

3.9. Хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгсөн баг, эсвэл уг ажлыг хариуцсан ажилтан нь үнэлгээний эцсийн үр дүнг удирдлагад танилцуулна.

---oOo---